

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2024/92/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох

Утас: 70592439

Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Наранцацрал

Утас: 70592225

Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ихбаяр

Утас: 70593113

Цахим хаяг: ikhbayard@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДУГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл.....	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал.....	Error! Bookmark not defined.
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	Error! Bookmark not defined.
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.5.1 Завсрын аудитын талаар.....	Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	Error! Bookmark not defined.
5.1 Төлбөрийн акт.....	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2024-02-22 № 29

танай _____-ны № _____-т

ДУНДГОВЬ АЙМГИЙН ДЭРЭН
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Г.ЗУЛБААТАР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дэрэн сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар эд хөрөнгийн хагас жилийн тооллого хийгээгүй, жилийн эцсийн тооллогыг чанаргүй хийсэн, тооллогын явцад хяналт тавиагүй, санхүүгийн тайлан дахь үндсэн хөрөнгийн дүн 6.2 сая төгрөгөөр, бараа материалын дүн 3.8 сая төгрөгөөр тооллогын бүртгэлээс зөрүүтэй, тооцоог бодож, баталгаажуулаагүй, мөн 2023 онд байгууллагын албан хэрэгцээнд ашиглаж байгаа 3 авто машинд зарцуулсан шатахууныг хяналтгүй зарцуулж, зарцуулалтын тооцоог бодож баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т /холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах/ тус хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т /анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 390 дүгээр тушаалын 1-р хавсралтыг тус тус зөрчсөн байна.

Залруулагдаагүй алдаа нь урьдчилан тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 12.1 дахин их, үндсэн хөрөнгө, бараа материалын дүн тооллогын бүртгэлээс зөрүүтэй, тооцоог бодож, баталгаажуулаагүй, шатахууны зардлыг хяналтгүй зарцуулж, зарцуулалтын тооцоог бодож баталгаажуулаагүй, Бусад үндсэн хөрөнгийн зардлаас санхүүжүүлсэн 43.7 сая төгрөгийн өртөгтэй “Соёлын төвийн засвар”-ын ажлын худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, шууд худалдан авалт хийсэн зэрэг зөрчил нь шинж чанар агуулгын хувьд материаллаг, оршин байх, үнэлгээ ба хуваарилалт, эрх үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд үндсэн хөрөнгө 121.2 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд үүнээс 19.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 102.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авсан, Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2023 оны 7 дугаар сарын 01-ны өдрөөс төрийн албаны үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 1.6 дахин өссөн. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Дотоод хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг байгууллагын даргын 2022 оны А/25 дугаар тушаалаар шинэчлэн баталсан боловч байгууллагын үйл ажиллагаанд огт хяналт шалгалт хэрэгжүүлээгүй, төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нар нь төсөв санхүүд нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан асуудал нь нөлөө бүхий эрсдэлтэй асуудал байлаа.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 17 зорилт, 54 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, Дэрэн сумын Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 98.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>193,901,586.92</u>	<u>249,647,868.95</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	8,083,946.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	8,083,946.00
3121	Төгрөг	-	8,083,946.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	-	8,083,946.00
33	АВЛАГА	-	9,467.03
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	9,467.03
35	БАРАА МАТЕРИАЛ	183,901,586.92	231,554,455.92
351	Түүхий эд материал	16,500.00	9,500.00
35110	Тусгай зориулалттай материал	16,500.00	9,500.00
354	Хангамжийн материал	55,405,086.92	109,414,955.92
35410	Бичиг хэргийн материал	4,221,280.00	6,506,430.00
35420	Аж ахуйн материал	49,343,806.92	90,519,525.92
35430	Сэлбэг хэрэгсэл	-	8,209,000.00
35440	Түлш, шатах төслох материал	-	1,924,000.00
35450	Барилгын засварын материал	160,000.00	576,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,680,000.00	1,680,000.00
35600	Мал амьтад	128,480,000.00	122,130,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	10,000,000.00	10,000,000.00
36900	Борлуулах зорилгоор эзэмшиж буй бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	10,000,000.00	10,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>827,753,082.81</u>	<u>855,773,080.01</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	827,753,082.81	855,773,080.01
392	Биет хөрөнгө	825,145,482.81	848,528,855.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	861,103,601.31	861,103,601.31
39202	Хуримтлагдсан элэгдэл	(290,020,724.47)	(334,436,246.28)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	169,058,800.00	215,458,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(59,713,941.75)	(81,703,821.69)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	130,204,994.00	166,026,319.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(29,909,509.34)	(40,921,044.55)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	66,936,309.20	65,076,309.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	(38,909,451.97)	(31,674,187.41)
39214	Бусад үндсэн хөрөнгө	23,874,196.92	37,834,146.92
39215	Хуримтлагдсан элэгдэл	(7,478,791.09)	(8,235,021.49)
393	Биет бус хөрөнгө	2,607,600.00	7,244,225.00
39301	Програм хангамж	450,000.00	5,236,625.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(150,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	2,157,600.00	2,157,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,021,654,669.73</u>	<u>1,105,420,948.96</u>

Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,730,606.00</u>	<u>890,550.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,730,606.00	890,550.00
413	Өглөг	1,730,606.00	890,550.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,730,606.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	890,550.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,019,924,063.73</u>	<u>1,104,530,398.96</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,019,924,063.73	1,104,530,398.96
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	410,438,374.38	410,438,374.38
51101	Өмч: - төрийн	410,438,374.38	410,438,374.38
512	Хуримтлагдсан үр дүн	510,446,627.65	595,052,962.88
51210	Өмнөх үеийн үр дүн	299,836,216.19	510,446,627.65
51220	Тайлант үеийн үр дүн	210,610,411.46	84,606,335.23
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	99,039,061.70	99,039,061.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,021,654,669.73</u>	<u>1,105,420,948.96</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	761,091,411.00	806,376,445.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	302,856,635.00	190,115,956.00
120	Нийтлэг татварын бус орлого	302,856,635.00	190,115,956.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	302,856,635.00	190,115,956.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	923,000.00	6,852,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,329,946.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	301,933,635.00	178,933,510.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	458,234,776.00	616,260,489.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	37,944,776.00	30,548,289.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,360,000.00	17,830,635.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	24,584,776.00	12,717,654.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	420,290,000.00	585,712,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	420,290,000.00	585,712,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	549,016,312.96	626,053,936.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	477,216,312.96	626,053,936.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	402,755,471.03	572,863,928.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	178,352,040.00	291,291,648.47
210101	Үндсэн цалин	141,320,880.00	216,476,815.49
210102	Нэмэгдэл	25,244,281.00	56,355,989.48
210104	Урамшуулал	11,786,879.00	18,458,843.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,018,923.94	34,636,048.00

Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210201	Тэтгэврийн даатгал	15,059,758.34	23,839,810.13
210202	Тэтгэмжийн даатгал	1,634,119.00	2,826,449.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,489,186.00	2,295,627.52
210204	Ажилгүйдлийн даатгал	332,018.00	507,732.36
210205	Эрүүл мэндийн даатгал	3,503,842.60	5,166,428.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,083,200.13	16,418,936.09
210301	Гэрэл, цахилгаан	1,794,200.13	6,076,636.09
210302	Түлш, халаалт	8,120,000.00	9,862,300.00
210303	Цэвэр, бохир ус	169,000.00	480,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,534,639.36	67,368,423.46
210401	Бичиг хэрэг	2,564,100.00	2,928,150.00
210402	Тээвэр, шатахуун	23,272,330.00	26,681,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,727,900.00	2,023,532.46
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	116,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,764,005.00	29,269,041.00
210408	Бараа материал акталсны зардал	4,206,304.36	6,350,000.00
2105	Нормативт зардал	35,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	35,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,167,500.00	47,400.00
210604	Урсгал засвар	7,167,500.00	47,400.00
2107	Томилолт, зочны зардал	6,344,000.00	12,464,000.00
210702	Дотоод албан томилолт	6,344,000.00	12,464,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,428,686.00	12,257,540.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,640,250.00	10,955,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	222,357.00	427,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	123,170.00	309,171.20
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	360,000.00
210807	Газрын төлбөр	82,909.00	85,269.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	128,791,481.60	138,379,932.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,958,248.00	27,392,266.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00	975,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	95,733,233.60	110,012,666.34
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	74,460,841.93	53,190,007.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,566,400.00	21,050,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,800,000.00	6,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,520,000.00	7,200,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,626,400.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	620,000.00	7,850,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	50,894,441.93	32,140,007.75
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	50,894,441.93	26,006,714.75

Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

213405	Нэмэлт санхүүжилтын төвлөрүүлэх шилжүүлэг		6,133,293.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	71,800,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	71,800,000.00	-
223001	Бусад хөрөнгө	71,800,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	212,075,098.04	180,322,508.69
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,464,686.58	95,716,173.46
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,464,686.58	8,601,291.46
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал- үндсэн хөрөнгө		17,000,000.00
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал- бараа материал		70,114,882.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	210,610,411.46	84,606,335.23

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	459,157,776.00	627,442,935.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	923,000.00	11,182,446.00
120	Нийтлэг татварын бус орлого	923,000.00	11,182,446.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	923,000.00	11,182,446.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	923,000.00	6,852,500.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	-	4,329,946.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	458,234,776.00	616,260,489.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	37,944,776.00	30,548,289.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,360,000.00	17,830,635.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	24,584,776.00	12,717,654.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	420,290,000.00	585,712,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	420,290,000.00	585,712,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	374,042,964.00	497,467,682.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	374,042,964.00	497,467,682.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	299,582,122.07	444,277,674.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	176,621,433.00	293,031,721.50
210101	Үндсэн цалин	139,599,719.00	218,216,888.52
210102	Нэмэгдэл	25,235,441.00	56,355,989.48
210104	Урамшуулал	11,786,273.00	18,458,843.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,018,924.94	34,636,048.00
210201	Тэтгэврийн даатгал	15,059,758.34	23,839,810.13
210202	Тэтгэмжийн даатгал	1,634,119.00	2,826,449.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,489,186.00	2,295,627.52
210204	Ажилгүйдлийн даатгал	332,016.00	507,732.36

Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	3,503,845.60	5,166,428.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,083,200.13	16,418,936.09
210301	Гэрэл, цахилгаан	1,794,200.13	6,076,636.09
210302	Түлш, халаалт	8,120,000.00	9,862,300.00
210303	Цэвэр, бохир ус	169,000.00	480,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,033,630.00	32,543,032.46
210401	Бичиг хэрэг	2,112,500.00	5,144,900.00
210402	Тээвэр, шатахуун	18,762,080.00	21,312,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,727,900.00	2,023,532.46
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,996,050.00	2,108,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,435,100.00	1,953,700.00
2105	Нормативт зардал	35,000.00	645,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	35,000.00	645,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,657,700.00	2,814,500.00
210604	Урсгал засвар	3,657,700.00	2,814,500.00
2107	Томилолт, зочны зардал	6,344,000.00	12,464,000.00
210702	Дотоод албан томилолт	6,344,000.00	12,464,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,425,186.00	12,527,940.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,636,750.00	11,225,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	222,357.00	427,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	123,170.00	309,171.20
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	360,000.00
210807	Газрын төлбөр	82,909.00	85,269.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,363,048.00	39,196,496.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,263,048.00	37,856,496.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00	1,340,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	74,460,841.93	53,190,007.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,566,400.00	21,050,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,800,000.00	6,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,520,000.00	7,200,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,626,400.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	620,000.00	7,850,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	50,894,441.93	32,140,007.75
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	50,894,441.93	26,006,714.75
213405	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг		6,133,293.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>85,114,812.00</u>	<u>129,975,253.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	85,135,500.00	121,891,307.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	85,135,500.00	121,891,307.00

Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2200	Дотоод эх үүсвэрээр	85,135,500.00	121,891,307.00
223001	Бусад хөрөнгө	85,135,500.00	102,926,882.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	18,964,425.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(85,135,500.00)</u>	<u>(121,891,307.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(20,688.00)	8,083,946.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20,688.00	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	8,083,946.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	410,438,374.38	99,039,061.70	299,616,090.96	809,093,527.04
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	220,125.23	220,125.23
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	410,438,374.38	99,039,061.70	299,836,216.19	809,313,652.27
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	210,610,411.46	210,610,411.46
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	410,438,374.38	99,039,061.70	510,446,627.65	1,019,924,063.73
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	410,438,374.38	99,039,061.70	510,446,627.65	1,019,924,063.73
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	410,438,374.38	99,039,061.70	510,446,627.65	1,019,924,063.73
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	84,606,335.23	84,606,335.23
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	410,438,374.38	99,039,061.70	595,052,962.88	1,104,530,398.96

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	603,547,300.00	560,557,985.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	474,610,900.00	438,666,678.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	455,560,900.00	419,616,678.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	302,166,600.00	293,031,721.50
210101	Үндсэн цалин	218,539,800.00	218,216,888.52
210102	Нэмэгдэл	61,826,800.00	56,355,989.48
210104	Урамшуулал	21,800,000.00	18,458,843.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,605,000.00	34,636,048.00
210201	Тэтгэврийн даатгал	28,971,300.00	23,839,810.13

Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210202	Тэтгэмжийн даатгал	3,408,300.00	2,826,449.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,726,700.00	2,295,627.52
210204	Ажилгүйдлийн даатгал	681,700.00	507,732.36
210205	Эрүүл мэндийн даатгал	6,817,000.00	5,166,428.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,154,800.00	14,519,740.09
210301	Гэрэл, цахилгаан	5,992,500.00	4,573,440.09
210302	Түлш, халаалт	9,862,300.00	9,862,300.00
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	84,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,003,700.00	24,902,632.46
210401	Бичиг хэрэг	4,800,000.00	4,664,900.00
210402	Тээвэр, шатахуун	14,322,300.00	14,837,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,681,400.00	2,023,532.46
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,900,000.00	2,108,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,300,000.00	1,267,700.00
2105	Нормативт зардал	650,000.00	645,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	650,000.00	645,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,235,000.00	2,814,500.00
210604	Урсгал засвар	5,235,000.00	2,814,500.00
2107	Томилолт, зочны зардал	14,245,000.00	11,384,000.00
210702	Дотоод албан томилолт	14,245,000.00	11,384,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,954,700.00	1,302,540.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,076,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	824,000.00	427,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	583,000.00	309,171.20
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	499,700.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	600,000.00	360,000.00
210807	Газрын төлбөр	372,000.00	85,269.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,546,100.00	36,380,496.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,206,100.00	35,040,496.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,340,000.00	1,340,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,050,000.00	19,050,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,050,000.00	19,050,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	6,000,000.00	6,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,200,000.00	7,200,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,850,000.00	5,850,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	128,936,400.00	121,891,307.00
2200	Дотоод эх үүсвэрээр	128,936,400.00	121,891,307.00
223001	Бусад хөрөнгө	128,936,400.00	121,891,307.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	605,364,700.00	559,705,485.25
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	605,364,700.00	559,705,485.25
122005	Орон нутгийн төсвөөс	605,364,700.00	559,705,485.25

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	24,414,996.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	24,414,996.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,414,996.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,899,196.00
210301	Гэрэл, цахилгаан	1,503,196.00
210303	Цэвэр, бохир ус	396,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,640,400.00
210401	Бичиг хэрэг	480,000.00
210402	Тээвэр, шатахуун	6,474,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	686,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,080,000.00
210702	Дотоод албан томилолт	1,080,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,225,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,225,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	570,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	570,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	24,414,996.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,414,996.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,676,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,738,396.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **94,875.4** мянган төгрөгийн зөрчил илрүүлэн **845.4** мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, **94,030.0** мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах 8 албан шаардлага, төсвийн зарцуулалттай холбоотой 1 заалт бүхий зөвлөмжийг тус тус хүргүүлсэн.

Залруулсан алдаа:

Аудитаар нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой залруулгын алдаа¹ илрээгүй.

Залруулагдаагүй алдаа:

Аудитаар нийт **94,875.4** мянган төгрөгийн зөрчил² илэрснээс **845.4** мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, **94,030.0** мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, албан тушаалтанд хариуцлага тооцох санал хүргүүлэх асуудалтай холбоотой зөрчлийг арилгуулах 8 албан шаардлага, төсвийн зарцуулалттай холбоотой 1 заалт бүхий зөвлөмжийг тус тус хүргүүлсэн.

3.1. Төлбөрийн акт

1. Аудитаар албан хаагчид **245,375.00** төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалинг илүү тооцож олгосон. *(3,5 сар ажилласан Бэлчээр хоршоо, жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Б.Насандэлгэрт 6 сар ажилласан хугацаанд ногдох урамшуулал олгосон)*

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д */төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/* Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.4-д */Төрийн жинхэнэ албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоход Засгийн газраас баталсан төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журамд заасан нөхцөл, шалгуурыг баримтална/-*д заасныг тус тус зөрчсөн;

2. Бичиг хэргийн зардлаас сонин хэвлэлийн захиалгын төлбөрт **600,000.00** */Зургаан зуун мянган/* төгрөг төлж төсвийг зориулалт бусаар хэмнэлтгүй зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д */төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/*, Төрийн хэмнэлтийн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1. */Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно:/*, 12.1.3. */хэвлэлийн захиалгын төлбөр;/*, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Эдийн засгийн ангилал ашиглах заавар"-т **"Бичиг хэрэг зардал"** */Бичгийн болон тооцоолон бодох, хэвлэн олируулах, техник хэрэгсэлд шаардагдах тууз /хор/, бэх, бичгийн цаа, үдээс хавчаар, үзэг харандаа, албан хэргийн хавтас, албан бичгийн хэвлэмэл хуудас болон тэдгээртэй адилтгах бусад бараа худалдан авах зардал/* заасныг тус тус зөрчсөн.

3.2. Албан шаардлага

1. Орон тоо, цалингийн сан батлагдаагүй албан тушаалд ажилтан авч ажиллуулан төсвөөс **3,283,360.00** */Гурван сая хоёр зуун наян гурван мянга гурван зуун жаран/* төгрөгийн цалин бодож олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.2.5-д */төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зардал нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлж байх/*, 16.5.2 */батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;/*, 41.2.2 */батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах/*, 42.7 */... төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно/* заасныг зөрчсөн.

2. Байгууллагын албан хэрэгцээнд ашиглаж байгаа 3 авто машинд зарцуулсан **8,576,450.00** */Найман сая таван зуун далан зургаан мянга дөрвөн зуун тавин/* төгрөгийн тээвэр шатахууныг хяналтгүй зарцуулж, зарцуулалтын тооцоог хууль журмын дагуу бодож баталгаажуулаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 зүйлийн 16.5.2 */батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4. */Аж*

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан */буруу ойлгосон/*, хайнга хандсан */мартсан, тэмдэглээгүй орхисон/*,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ахуйн нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат, дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна/, Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1-р хавсралт /Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг үндэслэн тогтоож, мөрдөж ажиллах, шатахууны зарцуулалтын тооцоог тогтсон хугацаанд бодож, тооцоо бодсон актыг үйлдэж баталгаажуулах/ дахь заалтыг тус тус зөрчсөн;

3. Анхан шатны баримтын бүрдэл дутуу, анхан шатны баримтын үнэн зөв эсэх нь тодорхойгүй баримтаар бэлэн болон бус худалдан авалт хийж төсвөөс **7,932,100.00** /Долоон сая есөн зуун гучин хоёр мянга нэг зуун/ төгрөгийг үр ашиггүй зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т /*Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т /*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*/, 13.6 /анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна/, 13.7 /анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно/, 20 дугаар зүйлийн 20.1.4-т /*хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажсаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх*/ заасныг тус тус зөрчсөн;

4. Бусад үндсэн хөрөнгийн зардлаас санхүүжүүлсэн **43,736.400.00** /*Дөчин гурван сая долоон зуун гучин зургаан мянга дөрвөн зуун*/ төгрөгийн өртөгтэй “Соёлын төвийн барилгын засвар”-ын ажлын худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, шууд худалдан авалт хийсэн. /*Соёлын төвийн үүдийг хүлээлгийн өрөөгөөр тохижуулах засвар -20.0 сая төгрөг, Барилгын гадна пасадны засвар-17,7 сая төгрөг, Гамигаас хамгаалах эд зүйлсийн агуулахын засвар – 6.0 сая төгрөг*/

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах /ТБОНӨХБАҮХА/ тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-т /*Шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар*/, 33 дугаар зүйлийн 33.1 –д /*Бараа ажил үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно*/, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолын хавсралтын 2–т /*Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар нь бараа, ажлын хувьд – 20.0 сая*/ заасныг тус тус зөрчсөн

5. Жилийн эцсийн хөрөнгийн тооллогын явцад хяналт тавиагүй, тооцоог бодож баталгаажуулаагүй, тооллогын бүртгэлээрх хөрөнгийн үлдэгдлийг санхүүгийн тайланд дахь хөрөнгийн үлдэгдлээс **10,060,348.41** /*Арван сая жаран мянга гурван зуун дөчин найм*/ төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т /*Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана*/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т /*Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*/, 20.2.6-т /*Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*/ заасныг тус тус зөрчсөн;

6. Цахим дэлгүүрт бараа үйлчилгээгээ байршуулаагүй бусад этгээдээс **18,964,425.00** /*Арван найман сая есөн зуун жаран дөрвөн мянга дөрвөн зуун хорин таван*/ төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авсан.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.13-т /Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авах бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулснаас өөр этгээдээс худалдан авахыг хориглоно./, 48 дугаар зүйлийн 48.5-д /Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ./ Төрийн хэмнэлтийн хуулийн 14 дүгээр зүйл 14.4-т /Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно/ заасныг тус тус зөрчсөн

7. Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал **1,476,884.00 /Нэг сая дөрвөн зуун далан зургаан мянга найман зуун наян дөрвөн/** төгрөгийг цалингийн зардлаас төлсөн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т /Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Эдийн засгийн ангилал ашиглах заавар"-т **“Үндсэн цалин” /Цалингийн сүлжээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон бусад холбогдох эрх/ зүйн актын дагуу тогтоон олгож байгаа үндсэн болон байнгын гэрээт ажилтны албан тушаалын үндсэн цалин энэ ангилалд хамаарна.Эдгээр зардлуудыг бүлгийн дүнгээр хянаж болно/** заасныг тус тус зөрчсөн;

8. Засаг даргын Тамгын газрын дарга Г.Зулбаатар нь өмнөх аудитаар өгсөн зөрчил арилгуулах албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй, шилэн дансны цахим хуудаст мэдээлэл байршуулалттай холбоотой дараах зөрчлийг давтан гаргаж хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын 2023 оны шилэн дансны мэдээллийг шалгахад төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэртэй холбоотой 103.4 сая төгрөгийн 57 шийдвэрийг мэдээлээгүй. Шилэн дансны хугацаа хоцролтын хэрэгжилт 100 хувтай боловч мэдээлсэн байдлын хэрэгжилт 81.2 хувьтай. (Энэхүү зөрчил нь 2022 оны санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар илэрч албан шаардлага хүргүүлсэн.)

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн /Шилэн дансны зарчим/ 4.1.1-д /мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;/, /Шилэн дансны зарчим/ 4.1.3-т /тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;/, 6 дугаар зүйлийн 6.4-т /Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:/, 6.4.5-д /цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;/, 6.4.8-д /бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;/, 7.2 -т /Энэ хуулийн 7.1-д заасан эрх бүхий албан тушаалтан мэдээлэх үүргээ бусдад шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй./ заасныг тус тус зөрчсөн.

3.3. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хөрөнгийн зардлын төлөвлөлт зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бусад үндсэн хөрөнгийн зардлыг "Хүний нөөцийн хөтөлбөр", "сумын шинэчлэлийн дэд бүтцийн төлөвлөгөөний хэлэлцүүлэг", "Түншлэл-2023", "сүү хөтөлбөр" зэрэг арга хэмжээний урсгал зардал буюу бичиг хэрэг, шатахуун, хоол цай, авто машины сэлбэг, завсар үйлчилгээ зэрэгт зарцуулж төсвийг зориулалт бусаар үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулсан. Энэ нь хөрөнгийн зардал урсгал зардалд зориулалт бусаар, үр ашиггүй хэмнэлтгүй зарцуулагдах эрсдэлтэй байна. Төсвийн тухай хуулийн 6.4.1-д /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 16.5.2-т /батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;/, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т /Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Эдийн засгийн ангилал ашиглах заавар"-т **“Хөрөнгийн зардал” /Тухайн төсвийн жилд төсвийн хөрөнгөөр үл хөдлөх хөрөнгө бий болгох,**

барилга байгууламж, тоног төхөөрөмж худалдан авах, барилга байгууламжид засвар хийхтэй холбоотой зардлууд энд хамаарна./ заасныг зөрчиж мөн иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

“Байгууллагын 2024 оны төсөвт тусгагдсан **“Хөрөнгийн зардал”**-ын төсвөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг зааврын дагуу хөрөнгийн шинжтэй төсөл арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөж, төсвийг үр ашигтай үр, хэмнэлттэй, хяналттай зарцуулах”

Өгсөн зөвлөмжийг хуулийн хүрээнд хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар³т нотлох баримтын хамт ирүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

³ Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593113

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Жилийн эцсийн хөрөнгийн тооллогын явцад хяналт тавиагүй, тооцоог бодож баталгаажуулаагүй, тооллогын бүртгэлээрх хөрөнгийн үлдэгдлийг санхүүгийн тайланд дахь хөрөнгийн үлдэгдэлээс зөрүүтэй тайлагнасан.	1	10,060.3			1	10,060.3						
Байгууллагын албан хэрэгцээнд ашиглаж байгаа 3 авто машинд зарцуулсан тээвэр шатахууныг хяналтгүй зарцуулж, зарцуулалтын тооцоог хууль журмын дагуу бодож баталгаажуулаагүй.	1	8,576.4			1	8,576.4						
Орон тоо, цалингийн сан батлагдаагүй албан тушаалд ажилтан авч ажиллуулан цалингийн төсвөөс 3,283,360.00 төгрөгийн цалин бодож олгосон.	1	3,283.4			1	3283.4						
Албан хаагчид 245,375.00 төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалинг илүү тооцож олгосон.	1	245.4	1	245.4								
Бусад үндсэн хөрөнгийн зардлыг <i>"Хүний нөөцийн хөтөлбөр"</i> , <i>"сумын шинэчлэлийн дэд бүтцийн төлөвлөгөөний хэлэлцүүлэг"</i> , <i>"Түншлэл-2023"</i> , <i>"сүү хөтөлбөр"</i> зэрэг арга хэмжээний урсгал зардал буюу бичиг хэрэг, шатахуун, хоол цай, авто машины сэлбэг, завсар үйлчилгээ зэрэгт зарцуулж төсвийг зориулалт бусаар үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулсан.	-	-										

Анхан шатны баримтын бүрдэл дутуу, анхан шатны баримтын үнэн зөв эсэх нь тодорхойгүй баримтааар бэлэн болон бус худалдан авалт хийж төсвийг үр ашиггүй зарцуулсан.	1	7,932.1			1	7,932.1						
Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг цалингийн зардлаас төлсөн.	1	1,476.9			1	1,476.9						
Бичиг хэргийн зардлаас сонин хэвлэлийн үнэ төлж төсвийг зориулалт бусаар үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулсан.	1	600.0	1	600.0								
Бусад үндсэн хөрөнгийн зардлаас санхүүжүүлсэн 43,736.400.00 төгрөгийн өргөтгэй “Соёлын төвийн засвар”-ын ажлын худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, шууд худалдан авалт хийсэн.	1	43,736.4			1	43,736.4						
Нийт дүн	8	75,910.9	2	845.4	6	75,065.5	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил													
Засаг даргын Тамгын газрын дарга Б.Зулбаатар, нягтлан бодогч Б.Гантигмаа нар өмнөх аудитаар өгөгдсөн шилэн дансны цахим хуудаст мэдээлэл байршуулалттай холбоотой зөрчил арилгуулах албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргаж хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй.	1	-								1	-		
Дүн	1	-								1	-		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил													
Цахим дэлгүүрт бараа үйлчилгээгээ байршуулаагүй бусад этгээдээс тоног төхөөрөмж худалдан авсан.	1	18,964.4			1	18,964.4							
Дүн	1	18,964.4			1	18,964.4							
Нийт дүн	2	18,964.4	-	-	1	18,964.4	-	-	1	-	-	-	-